

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3 – 4

1. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төсөл

3 – 4

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
05 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 46 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ, П.Батчимэг, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Ц.Мөнхбат, З.Мэндсайхан, Н.Наранбаатар, А.Ундраа, Б.Уянга, Ж.Чинбүрэн..

Нэг. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхимд
12 цаг 46 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 54.2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдааны ирцийг танилцуулъя. Буланы Бейсен 3 дугаар тойрог, ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар 2 дугаар тойрог, ирсэн байна. Жигжидийн Батжаргал 5 дугаарт тойрог, ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог, ирсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар 1 дүгээрт тойрог, ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн жагсаалтаар, ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат 6 дугаар тойрог, ирсэн байна. Сүрэнжавын Лүндэг 5 дугаар тойрог, ирсэн байна. Мэндбаярын Мандхай жагсаалтаар ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7 дугаар тойрог, ирсэн байна. Бадрахын Найдалаа жагсаалтаар ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр 6 дугаар тойрог ирсэн байна. Ринченбямбын Сэддорж 7 дугаар тойрог, ирсэн байна. Хэлэлцэх асуудал

Нэг.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Байнгын хорооны 2024 оны 7 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Агаарын бохирдол утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонссонтой холбогдуулан боловсруулсан ийм асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүн байхгүй байна.

Нэг.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийг хэлэлцэн дэмжсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр орно. Үүнээс өмнө Байнгын хороо хуралдаж,

тогтоолын төслийн хүчин төгөлдөр болох хугацааг ярилцах шаардлагатай болсон тул хүчин төгөлдөр болох хугацаа 5 сарын 1 гэж байгаа.

Үүнийг 6 дугаар сарын 15 байхаар өөрчлөх санал гаргах тийм юм байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын санал хураалт явуулна тийм ээ, тийм.

Энэ тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Тогтоолын төсөл 60-аас 69.2 хувьтай батлагдаж байна. Дэмжигдлээ.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны гишүүдэд баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ГЭРЭЭТ АЖИЛТАН**

Д.ЭНЭБИШ